

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ



20 24 оны 04 сарын 29 өдөр

№ SR-2024-05

Улаанбаатар хот

Банкны 2023 оны жилийн эцсийн цэвэр ашгаас
ногдол ашиг хуваарилах тухай

Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1 дэх хэсэг, ХасБанк ХК ("Банк")-ийн Дүрмийн 8.6.(ii) дахь заалтыг тус тус үндэслэн Банкны Хувьцаа эзэмшигчдийн 2024 оны 4 дүгээр сарын 29-ний өдрийн ээлжит хурлаар хэлэлцээд дараах шийдвэрийг гаргав:

ТЭМДЭГЛЭХ нь:

- Банкны Дүрэмд зааснаар ногдол ашиг хуваарилах эсэх нь стратегийн асуудал болохын хувьд Банкны хувьцаа эзэмшигчдийн хурлаар эцэслэн батлагдах шаардлагатай болохыг;
- Банкны Төлөөлөн удирдах зөвлөл ("ТУЗ") нь 2023 оны аудитлагдсан санхүүгийн тайлангийн үр дүнгээс шалтгаалан, Банкны 2023 оны цэвэр ашгаас Банкны хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг мөнгөн хэлбэрээр хуваарилах ("Ногдол ашиг")-ыг 2024 оны 02 дугаар сарын 19-ний өдрийн R-2024-02 дугаар тогтоолоороо хувьцаа эзэмшигчдэд санал болгосныг;
- ТУЗ нь 2024 оны 3 дугаар сарын 15-ны өдрийн R-2024-19 дүгээр тогтоолоороо 2023 оны аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайланг баталсан бөгөөд тус тайлан аливаа материаллаг өөрчлөлтгүйгээр батлагдсан болохыг; мөн
- Хувьцаа эзэмшигчид нь ТУЗ-өөс зөвлөмж болгосны дагуу Монголбанк зөвшөөрөл олгосон тохиолдолд, Банкны Дүрмийн 8.6.(ii) дахь заалтыг үндэслэн дор дурдсан дүнгээр Ногдол ашгийг зарлан хуваарилахыг дэмжсэн болохыг тус тус тэмдэглэв.

ТОГТООХ нь:

- Ногдол ашигт нийт 26,580,675,000.00 (хорин зургаан тэрбум таван зуун наян сая зургаан зуун далан таван мянга) төгрөг буюу нэгж хувьцаанд 25.25 (хорин таван төгрөг хорин таван мөнгө) төгрөг зарлан хуваарилсугай.
- Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалтыг гаргах бүртгэлийн өдөр болох 2024 оны 4 дүгээр сарын 09-ний өдрийг Ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдөр байхаар тогтоосугай.
- Монголбанкны зөвшөөрлийг хүлээн авсан өдөр эсхүл энэхүү шийдвэр батлагдсан өдрийн аль сүүлийн өдрөөс хойш 7 хоногоос хэтрүүлэлгүйгээр Банкны ногдол ашгийг мөнгөн хэлбэрээр төлсүгэй. Хувьцаа эзэмшигч нь ХасБанкны дансаараа дамжуулан

ногдол ашгаа авахаар бичгээр хүсэлт гаргаснаас бусад тохиолдолд Үнэт Цаасны
Төвлөрсөн Хадгаламжийн Төвөөр дамжуулан ногдол ашгийг тараасугай.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ХУРЛЫН ДАРГА



САНЖАЙ ГҮПТА